



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/28

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн “Эрүүл шүд” 322 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 322 дугаар тогтоолын дагуу “Эрүүл шүд” арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх, сургуулийн орчинд шүд угаах цаг, хэсэг бий болгож хэвшүүлэхтэй холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч нарын сургалтын зардалд 2,378,000 (хоёр сая гурван зуун далан найман мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 2,378,000 (хоёр сая гурван зуун далан найман мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.


ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0835

Аймгийн Засаг даргын 2024 оны 17 дүгээр
сарын 23-ны өдрийн 17/23 дугаар
захирамжийн хавсралт



Өвөрхангай аймгийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллага,
Ерөнхий боловсролын сургуулийн эмч нарт зохион байгуулах
“Амны хөндийн эрүүл ахуй” сэдэвт сургалтын зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ	Тооцоолол	Нийт үнэ
1	Цайны зардал	Төгрөг	82	9000	1 өдөр*82*9000 төгрөг	738,000
2	Үдийн хоолны зардал	Төгрөг	82	20000	1 өдөр*82*20000 төгрөг	1,640,000
	Нийт					2,378,000

-оОо-